

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/06/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: dolqorsuren@audit.gov.mn Ахлах аудитор О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: bayarmaa@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ч.СҮХБОЛД
ТАНАА

2024.03.25 № 07/480
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосныг үндэслэн алба хаагчдын цалинг нэмэгдүүлснээс шалтгаалан цалингийн зардал өмнөх оноос 96,351.8 сая төгрөгөөр буюу 53.0 хувиар өссөн байна.

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Цагдаагийн газарт аймаг, нийслэлийн Засаг дарга болон ИТХ-аас цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, нэгдсэн арга хэмжээний зардалд 10,110.6 сая төгрөг, Дотоодын цэргийн 810 дугаар ангийн хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардалд 11,080.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2018 оны 09 дүгээр тогтоолоор Монгол тамга ТӨҮГ-ыг татан буулгах ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт танилцуулахыг даалгасан боловч одоо хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 50 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 98.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98,675,042.5	127,710,002.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,350,659.3	15,587,586.6
33	АВЛАГА	228,465.3	1,793,832.1
34	УРЬДЧИЛГАА	26,873,940.4	42,801,515.9
35	БАРАА МАТЕРИАЛ	51,438,608.3	60,944,545.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	6,783,369.1	6,582,522.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	235,749,007.6	249,203,135.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	235,749,007.6	249,203,135.2
39200	Биет хөрөнгө	216,662,000.4	227,692,795.6
39300	Биет бус хөрөнгө	19,087,007.2	21,510,339.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	334,424,050.1	376,913,137.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,249,188.7	13,071,679.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,249,188.7	13,071,679.2
41300	Өглөг	195,475.8	497,022.6
41400	Урьдчилж орсон орлого	12,053,712.9	12,574,656.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	322,174,861.4	363,841,458.2
51	Засгийн газрын хувь оролцоо	322,174,861.4	363,841,458.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	84,507,689.4	86,512,622.1
51200	Хуримтлагдсан үр дүн	182,172,154.2	222,114,924.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55,495,017.9	55,213,911.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	334,424,050.1	376,913,137.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	332,162,416.6	458,948,427.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,028,948.2	40,169,789.8
120	Нийтлэг татварын бус орлого	26,630,139.6	38,988,781.6
122	Тусламжийн орлого	398,808.6	1,181,008.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	305,133,468.4	418,778,637.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	300,463,846.1	417,588,383.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	300,463,846.1	417,588,383.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267,275,549.4	374,304,456.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,755,463.5	275,905,374.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,507,126.3	6,497,126.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,912,518.7	7,094,658.1
2104	Хангамж, бараа материалын зардал	13,289,097.1	14,159,556.0
2105	Нормативт зардал	12,186,088.8	13,661,056.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,139,173.1	3,097,762.2
2107	Томилолт, зочны зардал	1,229,563.7	690,054.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,451,306.1	22,523,719.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,805,212.1	30,675,149.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,188,296.7	43,283,926.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	31,698,570.5	41,360,043.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	919.3	89,443.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,442,991.4	1,855,232.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	25,256,498.4	39,594,254.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	332,109,244.4	440,069,303.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,311,991.2	21,387,115.4
120	Нийтлэг татварын бус орлого	26,311,991.2	21,387,115.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	305,797,253.2	418,682,187.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	295,350,011.0	407,528,952.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	295,350,011.0	407,528,952.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	261,695,688.4	363,776,056.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,787,292.0	278,139,091.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,545,476.2	6,670,846.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,901,229.8	7,160,132.8
2104	Хангамж, бараа материалын зардал	11,182,363.3	11,222,450.9
2105	Нормативт зардал	13,994,584.7	12,287,538.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,947,978.5	10,450,006.7
2107	Томилолт, зочны зардал	1,174,804.9	764,551.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,283,836.4	32,957,349.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,878,122.6	4,124,089.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,654,322.6	43,752,896.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	36,759,233.4	32,540,350.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	25,863,630.8	30,476,317.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,863,630.8	30,476,317.4
2200	Дотоод эх үүсвэрээр	25,863,630.8	30,476,317.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(25,863,630.8)	(30,476,317.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	47,634.2	172,894.1
14	Бусад эх үүсвэр	47,634.2	172,894.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	10,943,236.8	2,236,927.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,407,422.5	13,350,659.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,350,659.3	15,587,586.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,461,704.3	-	296,461,704.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,014,066.1	-	1,014,066.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	297,475,770.4	-	297,475,770.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(999,179.5)	-	(999,179.5)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	441,772.1	-	441,772.1
Тайлант үеийн үр дүн	25,256,498.4	-	25,256,498.4
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	322,174,861.4	-	322,174,861.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	348,515.3	-	348,515.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	322,523,376.7	-	322,523,376.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(281,106.1)	-	(281,106.1)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,004,932.7	-	2,004,932.7
Тайлант үеийн үр дүн	39,594,254.9	-	39,594,254.9
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,841,458.2	-	363,841,458.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	385,632,552,800.00	385,346,728,888.27	285,823,911.73	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	378,183,052,800.00	377,899,940,080.27	283,112,719.73	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,137,886,300.00	345,894,530,620.34	243,355,679.66	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,611,116,800.00	266,566,653,723.87	44,463,076.13	100.0
Үндсэн цалин	160,324,000,800.00	154,057,551,502.93	6,266,449,297.07	96.1
Нэмэгдэл	85,214,429,500.00	91,534,896,127.43	(6,320,466,627.43)	107.4
Унаа хоолны хөнгөлөлт	3,877,520,000.00	3,239,653,642.44	637,866,357.56	83.5
Урамшуулал	5,661,701,000.00	9,540,117,689.65	(3,878,416,689.65)	168.5
Гэрээт ажлын хөлс	11,533,465,500.00	8,194,434,761.42	3,339,030,738.58	71.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,154,830,900.00	6,143,720,312.73	11,110,587.27	99.8
Тэтгэврийн даатгал	-	18,615,113.76	(18,615,113.76)	-
Тэтгэмжийн даатгал	-	2,190,011.85	(2,190,011.85)	-
ҮОМШӨ-ний даатгал	-	1,712,410.39	(1,712,410.39)	-
Ажилгүйдлийн даатгал	-	373,930.33	(373,930.33)	-
Эрүүл мэндийн даатгал	6,154,830,900.00	6,120,828,846.40	34,002,053.60	99.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,045,236,600.00	7,017,864,664.74	27,371,935.26	99.6
Гэрэл, цахилгаан	2,661,294,000.00	2,664,454,614.02	(3,160,614.02)	100.1
Түлш, халаалт	3,702,710,600.00	3,672,609,129.85	30,101,470.15	99.2
Цэвэр, бохир ус	589,490,800.00	591,176,483.98	(1,685,683.98)	100.3
Байрны түрээс	91,741,200.00	89,624,436.89	2,116,763.11	97.7
Хангамж, бараа материалын зардал	9,520,546,000.00	9,510,564,925.82	9,981,074.18	99.9
Бичиг хэрэг	767,792,600.00	773,160,548.03	(5,367,948.03)	100.7
Тээвэр, шатахуун	7,880,321,500.00	7,855,649,208.94	24,672,291.06	99.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	520,400,300.00	524,558,247.16	(4,157,947.16)	100.8
Ном, хэвлэл	16,455,000.00	16,398,532.00	56,468.00	99.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,372,100.00	25,888,403.00	1,483,697.00	94.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	308,204,500.00	314,909,986.69	(6,705,486.69)	102.2
Нормативт зардал	10,831,912,700.00	10,824,059,972.75	7,852,727.25	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,464,500.00	54,899,606.00	564,894.00	99.0
Хоол, хүнс	1,691,032,000.00	1,685,415,123.75	5,616,876.25	99.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,085,416,200.00	9,083,745,243.00	1,670,957.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	9,103,873,700.00	9,098,870,805.74	5,002,894.26	99.9
Багаж, техник, хэрэгсэл	6,819,523,900.00	6,817,878,260.80	1,645,639.20	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	138,268,400.00	136,394,220.94	1,874,179.06	98.6
Урсгал засвар	2,146,081,400.00	2,144,598,324.00	1,483,076.00	99.9
Томилолт, зочны зардал	475,319,500.00	466,748,727.00	8,570,773.00	98.2
Гадаад албан томилолт	88,567,300.00	88,566,966.00	334.00	100.0
Дотоод албан томилолт	367,252,200.00	361,028,861.00	6,223,339.00	98.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	19,500,000.00	17,152,900.00	2,347,100.00	88.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,406,885,000.00	34,279,194,985.69	127,690,014.31	99.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,239,945,600.00	33,120,269,953.57	119,675,646.43	99.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	299,141,300.00	299,141,226.12	73.88	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	117,719,700.00	114,429,055.00	3,290,645.00	97.2
Тээврийн хэрэгслийн оношилгоо	28,895,000.00	27,514,073.00	1,380,927.00	95.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	289,163,100.00	289,162,764.00	336.00	100.0
Газрын төлбөр	86,380,900.00	83,038,564.00	3,342,336.00	96.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	344,833,000.00	344,832,950.00	50.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,988,165,100.00	1,986,852,502.00	1,312,598.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	260,777,400.00	260,777,374.00	26.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,727,387,700.00	1,726,075,128.00	1,312,572.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,045,166,500.00	32,005,409,459.93	39,757,040.07	99.9

Засгийн газрын урсгал шилжүүлэг	107,027,100.00	107,027,099.33	0.67	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	107,027,100.00	107,027,099.33	0.67	100.0
Бусад урсгал шилжүүлэг	31,938,139,400.00	31,898,382,360.60	39,757,039.40	99.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	583,677,300.00	573,579,580.00	10,097,720.00	98.3
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,049,178,700.00	1,049,178,700.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,565,883,100.00	19,564,667,727.00	1,215,373.00	100.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,174,217,100.00	3,167,604,357.60	6,612,742.40	99.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,565,183,200.00	7,543,351,996.00	21,831,204.00	99.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,449,500,000.00	7,446,788,808.00	2,711,192.00	100.0
Барилга байгууламж	7,449,500,000.00	7,446,788,808.00	2,711,192.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	385,632,552,800.00	385,720,399,871.65	(87,847,071.65)	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	375,827,258,100.00	370,635,241,163.16	5,192,016,936.84	98.6
Улсын төсвөөс санхүүжих	375,827,258,100.00	370,635,241,163.16	5,192,016,936.84	98.6
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	252,495,000.00	348,042,400.00	(95,547,400.00)	137.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	252,495,000.00	348,042,400.00	(95,547,400.00)	137.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,552,799,700.00	14,737,116,308.49	(5,184,316,608.49)	154.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,552,799,700.00	14,737,116,308.49	(5,184,316,608.49)	154.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	350,000.00	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	350,000.00	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	55	55	-	100.0
Төсвийн байгууллага	55	55	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	11594	10753	841	92.7
Удирдах ажилтан	183	166	17	90.7
Гүйцэтгэх ажилтан	10139	9365	774	92.4
Үйлчлэх ажилтан	508	468	40	92.1
Гэрээт ажилтан	764	754	10	98.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ОРЛОГЫН ДҮН	-	42,558,242,377.41
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	397,697,900.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,922,709,455.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,161,293,839.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	31,076,541,183.41
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	42,558,242,377.41
А. УРСГАЛ ЗАРДАЛ	-	25,571,504,026.41
1. БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	22,558,864,903.69
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	11,535,664,863.78
Үндсэн цалин	-	6,514,876,015.90
Нэмэгдэл	-	349,580,039.32
Унаа хоолны хөнгөлөлт	-	16,288,000.00
Урамшуулал	-	2,131,528,409.44
Гэрээт ажлын хөлс	-	2,523,392,399.12
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	526,148,560.84
Тэтгэврийн даатгал	-	64,680,478.55
Тэтгэмжийн даатгал	-	407,471.81
ҮОМШӨ-ний даатгал	-	325,977.45
Ажилгүйдлийн даатгал	-	50,150.00
Эрүүл мэндийн даатгал	-	460,684,483.03
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,497,051,479.07
Гэрэл, цахилгаан	-	36,861,188.09
Түлш, халаалт	-	89,748,506.16
Цэвэр, бохир ус	-	5,808,434.00
Бичиг хэрэг	-	246,065,048.00
Тээвэр, шатахуун	-	584,453,769.75
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	138,440,662.28
Ном, хэвлэл	-	1,441,100.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,223,399.98
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	737,880,089.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	56,330,300.00
Хоол, хүнс	-	1,177,037,281.81
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	197,764,083.00
Багаж, техник, хэрэгсэл	-	2,368,080,802.20
Тавилга	-	199,704,296.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	20,619,300.00
Урсгал засвар	-	768,920,760.00
Гадаад албан томиллолт	-	128,342,883.00
Дотоод албан томиллолт	-	169,460,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төл	-	1,891,113,964.04
Газрын төлбөр	-	2,368,640.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,124,615,916.76
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	550,771,055.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,012,639,122.72
Бусад урсгал шилжүүлэг	-	1,547,688,199.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,631,470.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,542,056,729.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,464,950,923.72
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,464,950,923.72
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,986,738,351.00
Дотоод эх үүсвэрээр	-	16,986,738,351.00
Барилга байгууламж	-	6,875,126,053.00
Тоног төхөөрөмж	-	9,845,093,108.00
Бусад хөрөнгө	-	266,519,190.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 305.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргахгүй байх 275.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 29.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 1,568.3 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,779.7 сая төгрөгөөр бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Төвлөрүүлэн захирагч

Албан шаардлага

Тээврийн цагдаагийн алба нь босго үнэд багтаан олон салгаж, шууд гэрээ байгуулан 48 нэр төрлийн 275.7 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа босго үнэд багтаан олон салгаж, шууд гэрээ байгуулахгүй байх, хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

Зөвлөмж

1.1 Тайлант онд алба хаагчийн ёслолын богино ханцуйтай цамц 3500 ширхэг, албаны богино ханцуйтай цамц 3550 ширхэг, нийт 393,354.8 мянган төгрөгөөр бэлтгэн нийлүүлэх гэрээг Асралт баян хайрхан ХХК-тай байгуулж, он дамжин хэрэгжүүлэхээр сунгаж, урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилтийг бүрэн олгосон боловч барааг бэлтгэн нийлүүлж дуусаагүй,

1.2 Алба хаагчийн ноосон цамц 1500 ширхэг, тэмээний ноосон хантааз 1800 ширхгийг, нийт 430.8 сая төгрөгөөр бэлтгэн нийлүүлэх гэрээг Ашид нэт ХХК-тай байгуулсан боловч 983 ширхэг 137.8 сая төгрөгийн тэмээний ноосон хантаазыг нийлүүлээгүй, он дамжин хэрэгжүүлэхээр нэмэлт гэрээг байгуулж, урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилтийг бүрэн олгосон ч тусгай материалын дутагдлаас шалтгаалан гүйцэтгэл дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т "төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэрийг гаргахгүй байх, гэрээний гүйцэтгэл бүрэн хангагдаагүй байхад санхүүжилтийг нэмж, урьдчилан олгохгүй байх, алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

2. Ахмадын санд тайлант оны төсөвт зардлын хэмнэлтээс төсөвт батлагдаагүй нийт 2,893.1 сая төгрөгийн хөрөнгийг төвлөрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д

"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 1.3-т "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг **төсөвтөө жил бүр тусгана**" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн төсөвт ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөн батлуулах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллаж байгаад цэргийн тэтгэвэр тогтоолгосон нэр бүхий 9 генералд нийт 29,366.7 мянган төгрөгийн цолны цалинг олгосон байна.

Энэ нь Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө цэргийн алба хаагчид цалин хөлс олгоно", 9.2-т "Цэргийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн ба цэргийн цолны цалингаас ... бүрдэнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохгүй байх, баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

4. Харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4.3 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 86.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 албан шаардлага, 1,172.2 сая төгрөгийн 48 зөвлөмжийг хүргүүлсэн ба нийт 1,263.2 сая төгрөгийн 62 зөрчил¹ илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 3,105.7 сая төгрөгийн 45 алдаа илэрснээс, аудитын явцад 3,098.6 сая төгрөгийн 44 алдааг залруулж, 7.1 сая төгрөгийн 1 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар	3	126,808.2	1	96.0	2	126,712.2	3	126,808.2				
2	Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар	8	1,929,566.7			8	1,929,566.7	8	1,929,566.7				
3	Булган аймаг дахь Цагдаагийн газар	3	14,825.4	2	5,561.5	1	9,263.9	3	14,825.4				
4	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	7	2,207.4	2	444.7	5	1,762.7	7	2,207.4				
5	Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газар	6	178,054.2	2	2,546.0	4	175,508.2	6	178,054.2				
6	Дорнод аймаг дахь Цагдаагийн газар	2	63,874.8	1	8,042.0	1	55,832.8	2	63,874.8				
7	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	1	27,094.9	1	27,094.9			1	27,094.9				
8	Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар	3	31,040.5	1	20,000.0	2	11,040.5	3	31,040.5				
9	Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газар	2	7,101.4	1	-	1	7,101.4	1	-	1	7,101.4	1	7,101.4
10	Төв аймаг дахь Цагдаагийн газар	1	-	1	-			1	-				
11	Ховд аймаг дахь Цагдаагийн газар	2	56,879.3			2	56,879.3	2	56,879.3				
12	Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар	1	25,000.0			1	25,000.0	1	25,000.0				
13	СХД дүүрэг дэх Цагдаагийн газар	4	453,642.3			4	453,642.3	4	453,642.3				
14	Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газар	1	75,928.6			1	75,928.6	1	75,928.6				
15	Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	1	113,647.5	1	113,647.5			1	113,647.5				
	Дүн	45	3,105,671.2	13	177,432.6	32	2,928,238.6	44	3,098,569.8	1	7,101.4	1	7,101.4

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,263.2 сая төгрөгийн 62 зөрчил² илэрснээс, 4.3 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 86.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 албан шаардлага, 1,172.2 сая төгрөгийн 48 зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймаг дахь Цагдаагийн газар	1	210,047.9					1	210,047.9				
2	Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар	2	3,757.9	1	2,206.9			1	1,551.0				
3	Булган аймаг дахь Цагдаагийн газар	5	21,035.4	1	290.9	2	19,616.5	2	1,128.0				
4	Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газар	2	5,219.8			1	5,219.8	1	-				
5	Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар	2	1,554.1	1	1,554.1			1	-				
6	Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар	6	20,478.0					6	20,478.0				

7	Орхон аймаг дахь Цагдаагийн газар	4	15,562.3	1	234.6	1	2,554.5	2	12,773.2				
8	Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар	2	18,100.0			2	18,100.0						
9	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс	1	6,957.7					1	6,957.7				
10	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс	1	4,845.0					1	4,845.0				
11	Ховд аймаг дахь Цагдаагийн газар	3	45,935.0					3	45,935.0				
12	Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар	1	4,982.0					1	4,982.0				
13	Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар	2	28,914.9					2	28,914.9				
14	Санхүү, аж ахуйн алба	4	310,369.6			1	15,369.6	3	295,000.0				
15	Тэврийн цагдаагийн алба	1	275,684.7			1	275,684.7						
16	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	8	275,596.2			1	-	7	275,596.2				
17	Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар	3	6,066.2			1	-	2	6,066.2				
18	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар	2	56,887.2					2	56,887.2				
19	Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар	1	60,450.5					1	60,450.5				
20	Сонгино хайрхан дүүрэг дэх цагдаагийн газар	4	114,539.8			1	25,895.0	3	88,644.8				
21	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газар	1	1,287.7					1	1,287.7				
22	Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газар	3	44,354.4					3	44,354.4				
23	Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	1	1,540.0					1	1,540.0				
24	Налайх дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	3	4,771.5					3	4,771.5				
25	ЦЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан	4	29,366.7					4	29,366.7				
	Дүн	67	1,568,304.5	4	4,286.5	11	362,440.1	52	1,201,577.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1,611.5 сая төгрөгийн 34 зөрчил илэрснээс 18.2 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 1,593.2 сая төгрөгийн 29 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал									
4	Булган аймаг дахь Цагдаагийн газар	1	660,160.0					1	660,160.0
5	Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газар	1	-			1	-		
6	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	1	-					1	-
14	Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар	1	51,438.8					1	51,438.8
10	Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар	4	-					4	-
2	Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар	1	-					1	-
9	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс	1	-					1	-
	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэс	1				1	-		
13	Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар	1	75,454.5					1	75,454.5
8	Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	1	1,540.0					1	1,540.0
	Дүн	13	788,593.3			2	-	11	788,593.3
Бусад хууль, тогтоомжтой холбоотой асуудал									
1	Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газар	2	18,247.7			1	18,247.7	1	-
2	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	1	16,053.9					1	16,053.9
3	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	2	-					2	-
4	Ховд аймаг дахь Цагдаагийн газар	1	-					1	-
5	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	1	-					1	-
6	Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс	1	-					1	-
	Дүн	8	34,301.6			1	18,247.7	7	16,053.9
	Нийт дүн	34	1,611,488.2			5	18,247.7	29	1,593,240.5

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
2	ТШЗ	55	34	21		34			
	Нийт	56	35	21		35			